



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 5

Улаанбаатар хот


### Хуулийн төсөл нэн яаралтай хэлэлцүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх асуудлын тов, дарааллыг харгалзахгүйгээр Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлсүгэй.

2. Энэ захирамжийн 1 дэх заалтад заасан хуулийн төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо (Г.Тэмүүлэн)-нд даалгасугай.

ДАРГА



Г.ЗАНДАНШАТАР

2024000017



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА ГОМБОЖАВЫН  
ЗАНДАНШАТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.01.11 № 3Г-1/09  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай**

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

дэдл. 01.11 № ХТ/86  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай**

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт <sup>16</sup> хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000245002610



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn


2024.01.10 № 01/181

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль  
тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7  
дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн  
мэдүүлэхийг зөвшөөрөв.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761000123



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024. 01.10 № 1/131  
танай 2024. 01.10-ны № 208/81 -т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Б.ЭНХБАЯР

**151500002**

Doc.yam a5.2023

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлд:

**“8.ХЭЛЭЛЦСЭН нь:** Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоомжийн төсөл

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**Д.АМАРБАЯСГАЛАН**



**Б.ЖАВХЛАН**



**Б.ЭНХБАЯР**

## **ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

#### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6.4-т заасан “Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна.” зорилтын хүрээнд “Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан ногоон санхүүгийн үндэсний тогтолцоог дэмжин хөгжүүлж, олон улсын санхүүгийн арга хэлбэрийг ашиглан байгальд ээлтэй ногоон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ.” гэж заасан.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.2.5-д “Хот, суурин газрын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ” гэж, 3.2.13-т “Гэр хорооллын дундын болон захын бүсийг тэргүүн ээлжинд инженерийн дэд бүтэцтэй болгоход улс, орон нутгийн төсөв болон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулах, иргэдийн хүсэл, санаачилгад үндэслэн дэд бүтэц бүхий газрыг төр, эсхүл хувийн хэвшлийн орон сууцаар шууд солих замаар дараагийн орон сууц баригдах талбайг бий болгоно” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.5.3, 6.1.2, 6.1.3, 6.2.8-д хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх, Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийг эрчимжүүлж, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шархад, Дарь-Эх дэд төвүүдийг шинээр байгуулах, хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж, ногоон орон сууц,

шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхээр заасан.

## 1.2. Практик шаардлага

Олон улсын сайн жишгийн дагуу дэлхийн томоохон хотууд эдийн засаг, дэд бүтцийн төслүүдийн санхүүжилтийг хөрөнгийн зах зээл дээр үнэт цаас гаргах замаар шийдвэрлэж байна. 2022 оны байдлаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 64 хувийг Улаанбаатар хот дангаар үйлдвэрлэж буй томоохон зах зээл болоод байна. Хотын төсвийн 90.1 хувийг татварын орлогоор, 9.9 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна. Төсөв дагасан уг санхүүгийн схемийг шинэчлэн, олон улсын жишиг хотуудын эдийн засгийн хөгжилтэй ижил түвшинд хүрэх нэг чухал алхам бол хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох, томоохон төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэх механизм юм.

Монгол Улсын хөрөнгийн зах зээл 10 их наяд төгрөгийн хэмжээнд хүрч сүүлийн жилүүдэд Монгол Улсын Их хурал, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд эрчимтэй өсч байна. Гэвч дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжил хангалттай бус байгаа шалтгааны улмаас дотоодын зах зээлд орон нутгийн бонд гаргахад түүнийг худалдаж авах мэргэжлийн хөрөнгө оруулагч, ялангуяа орон нутгийн болон ногоон бонд зэрэг нийгмийн, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хариуцлагатай хөрөнгө оруулагчид хангалтгүй байгаа бөгөөд гол сонирхож буй субъект нь дотоодын арилжааны банкууд болж байна.

Арилжааны банкуудын хувьд аль болох өгөөж өндөр өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхолтой бөгөөд зах зээл дээр хэт давуу байдалтай байна. Улмаар зах зээл дээрх өгөөж өндөр, богино хугацаатай өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхол хандлагатай байгаагаас дотоодын хөрөнгийн зах зээлд ногоон болон орон нутгийн бондыг гаргахад бусад өрийн хэрэгслүүдтэй өгөөж, хугацааны хувьд өрсөлдөх шаардлага үүсэж тухайн нэр төрлийн бондуудын хувьд зардал өндөртэй босох үндэслэл болж байна. Мөн Банкны тухай хуулийн дагуу арилжааны банкны худалдан авах үнэт цаасны нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй бөгөөд улмаар нийслэлийн хэмжээний томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг дан дотоодын зах зээлээс босгох зах зээл хязгаарлагдмал байна.

Өрийн удирдлагын тухай хуульд нийслэл зөвхөн дотоодын зах зээлд өрийн хэрэгсэл гаргаж болно гэж заасан нь манай улсын хувьд өндөр хүүтэй өрийн хэрэгсэл гаргахад хүргэж байна.

Нөгөө талаар олон улсын зах зээл дээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах чиглэлээр дэлхийн улс орнууд далайцтай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Үүний нэг нь ногоон санхүүжилтийг хөгжүүлэх явдал бөгөөд хөгжингүй улс орнууд ихээхэн хэмжээний хөрөнгийг энэ чиглэлийн хөрөнгө оруулалтад зориулах чиг хандлага дэлхий даяар эрчимжиж байна байна. Түүнчлэн хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад чиглэсэн ногоон зээл болон бондын хүү бага бөгөөд 2023 оны 4 сарын Олон Улсын Валютын Сангийн судалгаанаас үзэхэд хөгжиж буй орнуудын хувьд ногоон болон энгийн бондын хүүгийн түвшиний зөрүү 2% орчим байна.



Мөн бага өгөөжтэй ч нийгмийн болон байгаль орчны хувьд эерэг нөлөөлөл авчрах төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулах “үр нөлөөллийн хөрөнгө оруулалт” хийх хөрөнгө оруулагч, донор байгууллагуудын сонирхол их байна. Эдгээр хөрөнгө оруулагчид ашгийн төлөө гэхээс илүүтэйгээр эрсдэлгүй, нийгмийн ач холбогдол өндөртэй өрийн хэрэгслүүдийг хямд эх үүсвэрээр санхүүжүүлэх сонирхол өндөр байна.

Иймд дээрх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн нийслэл олон улсын зах зээлд үнэт цаас гаргах боломжийг бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулна.

### **Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөлд нийслэл нь Засгийн газраас зөвшөөрсөн тодорхой төсөл, арга хэмжээ, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор гадаадын зах зээлд үнэт цаас гаргаж болох өөрчлөлтийг тусгана. Ингэхдээ зөвхөн Засгийн газрын баталгаатайгаар гаргах нөхцөлийг тусгана.

Хуулийн төслийг дагалдуулан боловсруулах Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд нийслэл нь Засгийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэгэн адил дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцаанд тус хууль хамаарахгүй байхаар нэмж тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Нийслэлийн бондыг олон улсын зах зээлд гаргах эрх зүйн орчныг бий болгосноор урт хугацаатай, зардал багатай өрийн хэрэгслийг зах зээлд гаргах, үүний үр дүнд төсөвт ирэх ачааллыг бууруулж, нийслэл хөгжлийн болон томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх, цаашлаад Монгол Улсын валютын нөөц бүрдүүлэлт, төгрөгийн ханшийн чангаралт, гадаадын хөрөнгө оруулалтад эерэг нөлөөлөл үзүүлнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Түүнчлэн нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар гаргах нийслэлийн гадаад үнэт цааст зориулж 2024 оны

төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргах Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

---o0o---

## **ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.2.5-д “Хот, суурин газрын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ” гэж, 3.2.13-т “Гэр хорооллын дундын болон захын бүсийг тэргүүн ээлжинд инженерийн дэд бүтэцтэй болгоход улс, орон нутгийн төсөв болон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулах, иргэдийн хүсэл, санаачилгад үндэслэн дэд бүтэц бүхий газрыг төр, эсхүл хувийн хэвшлийн орон сууцаар шууд солих замаар дараагийн орон сууц баригдах талбайг бий болгоно” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.2.5-д “Хот, суурин газрын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ” гэж, 3.2.13-т “Гэр хорооллын дундын болон захын бүсийг тэргүүн ээлжинд инженерийн дэд бүтэцтэй болгоход улс, орон нутгийн төсөв болон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулах, иргэдийн хүсэл, санаачилгад үндэслэн дэд бүтэц бүхий газрыг төр, эсхүл хувийн хэвшлийн орон сууцаар шууд солих замаар дараагийн орон сууц баригдах талбайг бий болгоно” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.5.3, 6.1.2, 6.1.3, 6.2.8-д хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх, Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийг эрчимжүүлж, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шархад, Дарь-Эх дэд төвүүдийг шинээр байгуулах, хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж, ногоон орон сууц, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, инженерийн хангамжтай орон сууц болон хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхээр заасан.

Олон улсын сайн жишгийн дагуу дэлхийн томоохон хотууд эдийн засаг, дэд бүтцийн төслүүдийн санхүүжилтийг хөрөнгийн зах зээл дээр үнэт цаас гаргах замаар шийдвэрлэж байна. 2022 оны байдлаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 64 хувийг Улаанбаатар хот дангаар үйлдвэрлэж буй томоохон зах зээл болоод байна. Хотын төсвийн 90.1 хувийг татварын орлогоор, 9.9 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна. Төсөв дагасан уг санхүүгийн схемийг шинэчлэн, олон улсын жишиг хотуудын эдийн засгийн хөгжилтэй ижил түвшинд хүрэх нэг чухал алхам бол хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох, томоохон төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэх механизм юм.

Монгол Улсын хөрөнгийн зах зээл 10 их наяд төгрөгийн хэмжээнд хүрч сүүлийн жилүүдэд Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд эрчимтэй өсч байна. Гэвч дотоодын хөрөнгийн зах зээлийн

хөгжил хангалтгүй байгаа шалтгааны улмаас дотоодын зах зээлд орон нутгийн бонд гаргахад түүнийг худалдаж авах мэргэжлийн хөрөнгө оруулагч, ялангуяа орон нутгийн болон ногоон бонд зэрэг нийгмийн, байгаль орчинд зэрэг нөлөө үзүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хариуцлагатай хөрөнгө оруулагчид хангалтгүй байгаа бөгөөд гол сонирхож буй субъект нь арилжааны банкууд болж байна.

Арилжааны банкуудын хувьд аль болох өгөөж өндөр өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхолтой бөгөөд зах зээл дээр хэт давуу байдалтай байна. Улмаар зах зээл дээрх өгөөж өндөр, богино хугацаатай өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхол хандлагатай байгаагаас дотоодын хөрөнгийн зах зээлд ногоон болон орон нутгийн бондыг гаргахад бусад өрийн хэрэгслүүдтэй өгөөж, хугацааны хувьд өрсөлдөх шаардлага үүсэж тухайн нэр төрлийн бондуудын хувьд зардал өндөртэй босох үндэслэл болж байна. Мөн Банкны тухай хуулийн дагуу арилжааны банкны худалдан авах үнэт цаасны нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй бөгөөд улмаар нийслэлийн хэмжээний томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг дан дотоодын зах зээлээс босгох зах зээл хязгаарлагдмал байна.

Өрийн удирдлагын тухай хуульд нийслэл зөвхөн дотоодын зах зээлд өрийн хэрэгсэл гаргаж болно гэж заасан нь манай улсын хувьд зардал ихтэй, өндөр хүүтэй өрийн хэрэгсэл гаргахад хүргэж байна.

Нөгөө талаар олон улсын зах зээл дээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах чиглэлээр дэлхийн улс орнууд далайцтай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Үүний нэг нь ногоон санхүүжилтийг хөгжүүлэх явдал бөгөөд хөгжингүй улс орнууд ихээхэн хэмжээний хөрөнгийг энэ чиглэлийн хөрөнгө оруулалтад зориулах чиг хандлага дэлхий даяар эрчимжиж байна байна. Түүнчлэн хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад чиглэсэн ногоон зээл болон бондын хүү бага бөгөөд 2023 оны 4 сарын Олон Улсын Валютын Сангийн судалгаанаас үзэхэд хөгжиж буй орнуудын хувьд ногоон болон энгийн бондын хүүгийн түвшиний зөрүү 2% орчим байна.

Мөн бага өгөөжтэй ч нийгмийн болон байгаль орчны хувьд зэрэг нөлөөлөл авчрах төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулах “үр нөлөөллийн хөрөнгө оруулалт” хийх хөрөнгө оруулагч, донор байгууллагуудын сонирхол их байна. Эдгээр хөрөнгө оруулагчид ашгийн төлөө гэхээс илүүтэйгээр эрсдэлгүй, нийгмийн ач холбогдол өндөртэй өрийн хэрэгслүүдийг хямд эх үүсвэрээр санхүүжүүлэх сонирхол өндөр байна.

Иймд дээрх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн нийслэл олон улсын зах зээлд үнэт цаас гаргах боломжийг бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсрууллаа.

Нийслэлийн үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргах эрх зүйн орчныг бий болгосноор урт хугацаатай, зардал багатай өрийн хэрэгслийг зах зээлд гаргах, үүний үр дүнд төсөвт ирэх ачааллыг бууруулж, нийслэл хөгжлийн болон томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх, цаашлаад Монгол Улсын валютын нөөц бүрдүүлэлт, төгрөгийн ханшийн чангаралт, гадаадын хөрөнгө оруулалтад зэрэг нөлөөлөл үзүүлнэ гэж үзэж байна.

**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**

Нийслэл нь олон улсын зах зээлд үнэт цаас гаргах боломжтой болсонтой холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан бөгөөд төсөлд нийслэл нь Засгийн газрын нэгэн адил дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцаанд тус хууль хамаарахгүй байхаар нэмж тусгасан.

Түүнчлэн нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар гаргах нийслэлийн гадаад үнэт цааст зориулж 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргах Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.17 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д тус тус заасны дагуу Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хууль, тогтоолын төсөл тул хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны үнэлгээ хийх шаардлагагүй болно.

---oOo---

## **ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Нийслэл Улаанбаатар хот 2022 оны байдлаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 64 хувийг дангаар үйлдвэрлэж байгаа бөгөөд хотын төсвийн 90.1 хувийг татварын орлогоор, 9.9 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна. Төсөв дагасан уг санхүүгийн схемийг шинэчлэн, олон улсын жишиг хотуудын эдийн засгийн хөгжилтэй ижил түвшинд хүрэх нэг чухал алхам бол хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох, томоохон төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэх механизм юм.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлд орон нутгийн болон ногоон бонд зэрэг нийгмийн, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хариуцлагатай хөрөнгө оруулагчид хангалтгүй байгаа бөгөөд гол сонирхож буй субъект нь арилжааны банкууд болж байна. Арилжааны банкуудын хувьд аль болох өгөөж өндөр өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхолтой бөгөөд Банкны тухай хуулийн дагуу арилжааны банкны худалдан авах үнэт цаасны нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй бөгөөд улмаар нийслэлийн хэмжээний томоохон төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг зөвхөн дотоодын зах зээлээс босгох зах зээл хязгаарлагдмал байна.

Нөгөө талаар олон улсын зах зээл дээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах чиглэлээр дэлхийн улс орнууд далайцтай арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Үүний нэг нь ногоон санхүүжилтийг хөгжүүлэх явдал бөгөөд хөгжингүй улс орнууд ихээхэн хэмжээний хөрөнгийг энэ чиглэлийн хөрөнгө оруулалтад зориулах чиг хандлага дэлхий даяар эрчимжиж байна. Түүнчлэн хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад чиглэсэн ногоон зээл болон бондын хүү бага бөгөөд 2023 оны 4 сарын Олон Улсын Валютын Сангийн судалгаанаас үзэхэд хөгжиж буй орнуудын хувьд ногоон болон энгийн бондын хүүгийн түвшиний зөрүү 2% орчим байна.

Мөн бага өгөөжтэй ч нийгмийн болон байгаль орчны хувьд эерэг нөлөөлөл авчрах төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулах “үр нөлөөллийн хөрөнгө оруулалт” хийх хөрөнгө оруулагч, донор байгууллагуудын сонирхол их байна. Эдгээр хөрөнгө оруулагчид ашгийн төлөө гэхээс илүүтэйгээр эрсдэлгүй, нийгмийн ач холбогдол өндөртэй өрийн хэрэгслүүдийг хямд эх үүсвэрээр санхүүжүүлэх сонирхол өндөр байна.

Иймд дээрх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн нийслэл олон улсын зах зээлд үнэт цаас гаргах боломжийг бүрдүүлэх зорилгоор Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсрууллаа.

Нийслэлийн үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргах эрх зүйн орчныг бий болгосноор урт хугацаатай, зардал багатай өрийн хэрэгслийг зах зээлд гаргах, үүний үр дүнд төсөвт ирэх ачааллыг бууруулж, нийслэл хөгжлийн болон томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх, цаашлаад Монгол Улсын валютын

нөөц бүрдүүлэлт, төгрөгийн ханшийн чангаралт, гадаадын хөрөнгө оруулалтад эерэг нөлөөлөл үзүүлнэ гэж үзэж байна.

Нийслэл нь олон улсын зах зээлд үнэт цаас гаргах боломжтой болсонтой холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан бөгөөд төсөлд нийслэл нь Засгийн газар, төрийн өмчит компанийн нэгэн адил дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцаанд тус хууль хамаарахгүй байхаар нэмж тусгасан.

Түүнчлэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар гаргах нийслэлийн гадаад үнэт цааст зориулж 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргах Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

---o0o---

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

**ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Өрийн удирдлагын тухай хуулийн 28<sup>1</sup> дугаар зүйлийн 28<sup>1.1</sup> дэх хэсгийн "дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно." гэсний дараа "Нийслэл нь гадаад үнэт цаасыг нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан, Засгийн газраас зөвшөөрсөн томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж болно." гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Өрийн удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалтын "дотоодын зах зээлд" гэснийг хассугай.

Гарын үсэг



Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА,  
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.3 дахь заалтын “Засгийн газар,” гэсний дараа “нийслэл,” гэж нэмсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

Засгийн газрын өрийн баталгаа гаргах  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар гаргах нийслэлийн гадаад үнэт цааст зориулж 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС

2024.01.11.

Улаанбаатар хот

Д/д	Албан тушаал	Нэр	Утас
1.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч	Х.Нямбаатар	99114118
2.	Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч	П.Сайнзориг	88110079
3.	Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч	Х.Номинчимэг	99998326
4.	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга	Б.Сүх-Очир	99011664
5.	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга	Л.Сонор	99066188
6.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захиргаа, хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх	Д.Цолмон	88101375
7.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	Д.Амгалан	99070489
8.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Өрийн удирдлагын тасгийн дарга	Л.Эрдэнэбадрах	99090549